

**“УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН АНГИЛЛЫГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 1995 ОНЫ 26 ДУГААР ТОГТООЛД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоол /цаашид “тогтоолын төсөл” гэх/-ын төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу үнэлсэн болно.

Тогтоолын төслийг аргачлалд заасны дагуу дараах үе шаттай хийлээ.

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Тогтоолын төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд заасан үндсэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Ойлгомжтой байдал;
- 3.Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тогтоолын төслийн зохицуулалт дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм.

Иймд тогтоолын төслийн зохицуулалт нь тогтоолын төслийн үзэл баримтлал буюу тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Ойлгомжтой байдал:

Тогтоолын төслийн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлнө. Тогтоолын төсөл нь

бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Харилцан уялдаа:

Тогтоолын төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж болон тогтоолын төсөлд тусгагдсан зохицуулалт нь хоорондоо зөрчилгүй байх, төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгах зорилгоор энэ шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт 1.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Тогтоолын төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Тогтоолын төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30, 35, 36 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Харилцан уялдаа	Тогтоолын төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад тухайн тогтоолын төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

“Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Тогтоолын төслийн зорилт:

Тогтоолын төслийн үзэл баримтлалын нэг дэх хэсэг буюу тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага хэсэгт “Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр”-ийн 3.4-т “Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн үдсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн, экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт улсын нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”, сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс байгаль орчин доройтох, байгалийн нөөц хомсдох үйл явц улам бүр эрчимжиж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх судалгааны ажлын тайлангаас үзэхэд манай орны нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр цөлжилтөнд өртөж, нийт бэлчээрийн 70 орчим хувь талхлагдаж, 300 гаруй зүйлийн амьтан, ургамал устах аюулд орж олон арван гол, горхи, булаг, шанд, нуур цөөрөм ширгээд байна.

Улсын байгалийн нөөц газарт авхуулхаар төлөвлөж буй Өндөр-Улаан сумын Азарга багийн Шаргачин гол дагуу Далтын нуруу орчим ураны орд байдаг бөгөөд уг ордын нөөцийн хувьд зүүн хойд талаараа Жаргалант сумын Асайт багт 10 хувь, баруун хойд талаараа Тариатын Мөрөн, Алтаад багт 10 хувь, Өндөр-Улааны Азарга багт 80 хувь тус тус хамаардаг байна. Үүнтэй холбогдуулан ашигт малтмал хайх, олборлох, байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын ус бохирдуулах зэрэг сөрөг үр дагавар гарч нутгийн оршин суугчдын эрх ашгийг хөндөж болзошгүй нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэхээс гадна аймаг, сумдын иргэдийн санал хүсэлт гарсан.

Иймд байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах, ногоон хөгжлийн түшиц газрыг бий болгоход экологийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьсан менежмент бүхий тогтолцоог бэхжүүлэн хамгаалах, түүндээ зохицсон уламжлалт аж ахуйгаа олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх үүднээс “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар

тогтоолд нэмэлт оруулах тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тусгасан байна.

Тогтоолын төслийн тогтоох хэсэгт Архангай аймгийн Жаргалант, Тариат, Өндөр-Улаан сумдын нутаг дахь “Далтын нуруу, Шаргачны голын ай сав”-ын сумын зарим хэсгийг хамруулан байгалийн нөөц газрын ангиллаар тусгай хамгаалалтад авахаар заасан нь мөн тогтоолын төслийн тогтоох хэсгийн 2 дахь хэсэгт Байгалийн нөөцийн газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч байгаа газрын нутгийн хилийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай гэх тогтоолын төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгыг биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30, 35, 36 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн тогтоолын төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Тогтоолын төсөл нь тогтоолын гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг гэсэн бүтэцтэй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн талаар аргачлалын 4.10 дахь заалтад заасан шалгах асуултад хариулах байдлаар үнэлгээг хийлээ:

Хүснэгт 2.

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	-	Улсын Их Хурлын тогтоолын төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	-	Улсын Их Хурлын тогтоолын төсөлд асуултад дурдсан хэсэг байхгүй болно.
4	Хуулийн төслийн зүйл, заалт	Тийм	Нийцэж байна.

	тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх		
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Давхардсан зохицуулалт байхгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд тусгагдаагүй.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Тогтоолын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тусгаагүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд ийм зохицуулалт байхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Ямар нэгэн зөрчил илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Тогтоолын төслийн зохицуулалтад хамаарахгүй байна.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Тогтоолын төслийн зохицуулалтад хамаарахгүй байна.

15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Шууд хамааралтай зохицуулалт байхгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Үгүй	Хууль тогтоомжийн тухай хуулийн 35.1-д “Монгол Улсын Их Хурлын тогтоол /цаашид “Тогтоол” гэх/-ын төсөл дараах шаардлагыг хангасан байна.”, 35.1.3-т “хариуцлагын хэм хэмжээ заахгүй байх.” гэж заасан.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд тогтоолын төслийн зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү төслийн үр нөлөө тооцох үнэлгээг “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийн хүрээнд хийлээ. Үнэлгээнд тогтоолын төсөл, үзэл баримтлалаас гадна тогтоолын төсөлтэй холбоотой мэдээлэл, тусгай хамгаалалтад авахаар тусгасан газар тус бүрийн талаарх судалгаа, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд зэрэг материалыг ашигласан болно.

Тогтоолын төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, тогтоолын төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэхийг аргачлалд заасны дагуу хийсэн үнэлгээг нэгтгэн дараахь дүгнэлт хийж, зөвлөмжийг боловсруулсан болно.

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Тогтоолын төслийн тогтоох хэсэгт Архангай аймгийн Жаргалант, Тариат, Өндөр-Улаан сумдын нутаг дахь “Далтын нуруу, Шаргачны голын ай сав”-ын байгалийн нөөц газарт авхаар батлахаар заасан нь тогтоолын төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгыг биелүүлэх боломжтой байна гэж үзлээ.

Ойлгомжтой байдал: Тогтоолын төсөл нь тогтоолын гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг гэсэн бүтэцтэй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Харилцан уялдааг хангасан байдал: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь зүйл заалт хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зохицуулалт агуулаагүй, хуульд заасан шаардлагыг хангасан байна.

ЗӨВЛӨМЖ:

“Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь зорилгодоо хүрэх боломжтой, тогтоолын төслийг дагаж мөрдөхөд ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байх тул дүгнэлтэд дурдсан тогтоолын төслийн дугаарлалт, холбогдох өөрчлөлтийг тусгаж, батлуулах боломжтой гэж үзэж байна.

---o0o---